

ХӨГЖЛИЙН БАНК ГЭДЭГ ЭЦСИЙН ДҮНДЭЭ БОЛ ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн дэд профессор, Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Б.ТҮВШИНТӨГС-тэй ярилцлаа.

Хөгжиж байгаа орны эдийн засгийн өсөлт савлагаатай байх нь түгээмэл

-Монголбанкнаас арилжааны банкуудын дүрмийн санг 16 тэрбум төгрөгөөр шинэчлэн тогтоолоо. Энэ нь арилжааны банкуудын нөөц хөрөнгийг нэмэгдүүлэхэд нөлөөлөх боловч жижиг банкуудын хувьд нэлээд ээдрээ дагуулах уу?

-Төв банкнаас өмнөх жилүүдэд удаа дараа иймэрхүү байдлаар үйл ажиллагаа явуулах болсон. Тэдгээрийн нэг нь өчигдрийн мэдээлэл болсон. Өмнө нь банкны дүрмийн санг хэд хэдэн удаа нэмэгдүүлж байсныг хүмүүс мэдэх байх. Дөрвөн тэрбум төгрөг байсан банкны дүрмийн санг найман тэрбум төгрөгөөр болгосон, хамгийн сүүлчийнх нь 16 тэрбум төгрөг болж байна. Олон Улсын Валютын сангийн Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын талаар хийсэн судалгааг харахад Монголын хэд хэдэн банк капитал буюу хөрөнгийн дутагдалтай гэж гарсан байсан. Зохистой харьцаа нь бага үзүүлэлттэй гарлаа гэж тэмдэглэсэн байна билээ. Ийм үед өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлбэл жижиг банкууд хоорондоо нэгдэж нэг том банк болох болов уу. Урт хугацаандаа Монголын банкны системд одоогийнхоос цөөн тооны томоохон банкууд үйл ажиллагаа явуулах бодлого руу ерөнхийдөө чиглэж байна.

-Арилжааны жижиг банкууд нэгдээд ирэхээр зээлийн хүү мэдэгдэхүйц буурах болов уу?

-Арилжааны банкууд нэгдээд зээлийн хүү буурна гэх гаргалгааг сайн ойлгохгүй байна. Би хувьдаа шууд зээлийн хүү буурна гэж хэлэхгүй. Бодлого боловсруулагчид зээлийн хүүг бууруулна гэж найдаад байх шиг байна л даа. Банкууд өөрийн хөрөнгөтэй болоод ирэхээрээ хадгаламжаараа дамжуулж хөрөнгө татахаас гадна, өөрсдийн хөрөнгөө зээлүүлэх учраас санхүүгийн эх үүсвэрээ арай л бага зардалтай олох боломжтой гэж үзэж байгаа юм билээ.

-Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, олон улсын байгууллагаас төсөөлж буй эдийн засгийн өсөлт хэр бодитой вэ. Энэ онд л гэхэд манай эдийн засгийн өсөлт 10.8 хувьтай гарна гэж таамаглаж байна?

-Дэлхийн улсуудыг хөгжсөн, хөгжиж буй гэж хоёр ангилах хэрэгтэй. Хөгжчихсөн, хөгжлийн түвшин нь нэлээд өндөр Голланд Улс гэхэд эдийн засгийн өсөлт дунджаар өндөр байдаггүй. Харин хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт байнгын савлагаатай. Зарим улсын эдийн засаг 10 хувиар өсч байхад, өөр нэг орны эдийн засаг тав хүртэлх хувиар бууж байх жишээтэй. Эдийн засгийн өсөлт нь хөгжиж байгаа орны хувьд савлагаатай байдаг нь түгээмэл. Үүний жишгээр Монгол Улсын эдийн засгийн

өсөлт нь савлагаа ихтэй. Манай улсын хувьд 2009 онд гэхэд л хасах эдийн засгийн бууралттай байсан. Өнгөрсөн онд эдийн засаг зургаан хувийн өсөлттэй гарлаа. Засгийн газар, Олон улсын байгууллагууд бүгдээрээ л 10 орчим хувийн эдийн засгийн өсөлтийн хүлээлттэй төсөөлж байна.

Эдийн засаг нь өндөр өсөлттэй хэдий ч ядуурлаа шийдэж чаддаггүй орнууд зөндөө

-Эдийн засгийн гэнэтийн өсөлт бодиттой юу. Иргэдийнх нь амьжиргаанд өөрчлөлт авчирсан таатай өсөлт манайд одоогоор алга гэж үзэж болох уу?

-Үүнийг илүү судалгаатай хариулах хэрэгтэй. Манай улс чинь “Мянганы хөгжил сан”-гийн зорилтыг биелүүлж байгаа. Өөрөөр хэлбэл, ядуурлын эсрэг тодорхой зорилт тавиад түүндээ хүрэх гэж яваа. Ядуурлыг бууруулах нэг стратеги нь эдийн засгийн өсөлтөөр дамжиж ядуурлыг бууруулна гэж үзэж байгаа. Гэтэл хийсэн судалгааг аваад үзэхээр эдийн засгийн өсөлт шууд ядуурлыг бууруулдаг тийм гаргалгаа бас ч түгээмэл биш юм. Эдийн засаг нь өндөр өсөлттэй хэдий ч ядуурлаа шийдэж чадаагүй орнууд зөндөө байна.

-Тэгвэл, Монголбанкны явуулж буй мөнгөний бодлого хэр оновчтой бодлого юм бол?

-Оновчтой, оновчгүй гэж хэлэхэд эртдэнэ. Ямар бодлогоо бид оновчтой гэдгээ тайлбарлах ёстой. Ямар шатны бодлогыг оновчгүй гэх үү гээд. Тиймээс мөнгөний бодлого дээр анхан шатны ойлголтоос эхлэх хэрэгтэй. Монголбанкнаас баримталж буй мөнгөний бодлогын зорилго юу болох гэдгээс хамаарна. Зорилгодоо төв банк хүрч байвал болж байна. Хүрэхгүй бол болохгүй нь гэж харна.

-Одоогийн төв банкны мөнгөний бодлого бол ерөнхийдөө инфляцыг нам төвшинд барих. Гэтэл зорилго бүхий инфляцаа нам төвшиндөө барьж чадахгүй л явна?

-Албан ёсны гэж үзвэл Монголбанк хэд хэдэн зорилтыг дэвшүүлсэн байдаг. Нэгдүгээрт, инфляцыг нам төвшинд барих, Хоёрдугаарт нь төгрөгийн ханшийг тогтвортой байлгах. Гэтэл энэ хоёр зорилго хоорондоо заримдаа зөрчилддөг. Хоёуланг нь зэрэг зорилгоо болгоод дэвшүүлвэл угаасаа учир дутагдалтай. Тиймээс Монголбанк зорилгоо одоогийнхоосоо бүр илүү тодорхой болгох шаардлагатай байна. Инфляцыг онилох гэж байгаа юм бол инфляцыг гол зорилгоо болгох ёстой. Өөрөөр хэлбэл, валютын ханшны зохицуулалтаа одоогийнхоосоо хязгаарлах нь зүйтэй. Эсвэл валютын ханшийг гол зорилгоо болгох гэж байвал инфляц гэж ерөөсөө дуугарах шаардлагагүй. Валютын ханшийг тогтворжуулах бодлогын хувьд мөнгөний бодлого гэж тодорхойлох бараг хэрэггүй дээ. Монголбанкны өмнө тавигдаж буй сонголт бол энэ.

-Төв банк инфляцыг л сонгох байх?

-Монголбанкны гол зорилго нь инфляцыг нам төвшинд барих. Сүүлийн тав, зургаан жилийг аваад үзэхээр төв банк заримдаа зорилгодоо хүрсэн, заримдаа хүрээгүй байх жишээтэй. Хямралын үед бол инфляц нэлээд өндөр өссөн. Төв банк хямралын үед ч инфляцынхаа зорилгыг биелүүлээгүй учраас мөнгөний бодлого нь оновчгүй гэж дүгнэж болохгүй. Хямралын үед бол байдал арай өөрөөр тавигдаж байсан. Монголбанкнаас үл хамаарсан гаднаас орж ирсэн шок их. Өөрөөр хэлбэл, мөнгөний бодлогын нөлөөлж болох зүйл гэж байна. Чадахгүй бас зүйл бий. Чадахгүй зүйлийнх нэг нь хямралын үе давамгайлсан учраас инфляцыг нам түвшинд барих зорилтоо биелүүлж чадаагүй хэрэг. Одоо бол эдийн засгийн гадаад нөхцөл байдал таатай байгаа учраас Монголбанк өмнөө тавьсан зорилгоо биелүүлж байна. Өндөр байсан инфляцаа 10 хувьдаа барьж байгаа. Үүнээс ч нам түвшинд барих хүлээлт байна. Зорилго нь ч энэ.

-Монголбанкны инфляцыг онилсон бодлогыг зарим эдийн засагчид шүүмжилдэг л дээ. Та тэдэнтэй санал нийлэх үү?

-Инфляц өөрөө олон хүчин зүйлээс шалтгаалж байдаг. Тийм учраас инфляцид нөлөөлж байгаа хүчин зүйлүүд дотроос Монголбанкны нөлөөлж чадахгүй хүчин зүйлүүд ч бий. Өөрөөр хэлбэл, гадна талаас нь харахад төв банк чадахгүй зүйл дээрээ хүртэл зорилт тавьж байх жишээтэй. Тиймээс төв банкнаас чадах зүйл дээрээ зорилт амлаад ажиллавал өөрсдийнх нь нэр хүндэд эерэг. Хэрэгжүүлж чадах зүйлийнхээ төлөө шүү дээ.

-Шатахуун хомсдох үед одоо ч инфляц гаарна гэсэн хүлээлт байв. Гэтэл инфляцад өөрчлөлт ороогүй байсан. Үүнээс үүдэн инфляцыг дарж байна уу гэсэн хардалга бий?

-Сүүлийн үед гарч байгаа бензиний үнийн өсөлт маш тодорхой жишээ нь. Монголбанк мөнгөний бодлогоор дамжуулж бензиний үнийг хянах боломжгүй. Ийм боломж ч байхгүй. Мөнгөний бодлогын хүрээний гадуурх хүчин зүйлээс тодорхойлох учраас бараг л тайлбарлах боломжгүй. Гэтэл шатахууны үнийн өсөлт өргөн хэрэглээний барааны үнэд нөлөөлж үүнээс үүдэн инфляц өсөхөд нөлөөлдөг. Иймэрхүү гадаад шокийн шинж чанартай нөлөөлөлд Монголбанк нэгэнт л нөлөөлж чадахгүй нь үнэн. Энэ хаврын хувьд махны үнэ инфляцад урьд өмнөх жилүүдийнх шиг нөлөөлсөнгүй. Махны үнийн өндөр өсөлт ч зах зээлд ажиглагдаагүй. Нөөцийн мах нэлээд хуримтлагдсан, зуд турхан болоогүй учраас махны нөлөөлөл инфляцад бага байж, өнөөдрийн ажиглагдаад байгаа тав, зургаан хувьтай инфляц гарч байна.

Монголбанкны мөнгөний бодлого хатуу бодлого биш ээ

-Инфляцыг тодорхойлох өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг шинэчлэх ёстой гэж үздэг. Өөрчлөх шаардлага бий юү?

-Инфляцыг тодорхойлох сагсны бүтцийг хэрэглээний үнийн индексээр тооцдог. Хэрэглээний үнийн индекс 256 бараа бүтээгдэхүүн ордог. Үүний бүтэц сайн муу гэдэг дээр олон судалгаа хийгээд хариулт нь гарчихсан. Одоогийн байгаа бүтэц дундаж айлын хэрэглээг зөв зохистой харуулж байгаа. Тиймээс шаардлага байхгүй.

-Инфляцийг нам төвшинд барихын тулд яах ёстой вэ?

-Монголбанкнаас баримталж байгаа мөнгөний бодлого хатуу бодлого биш ээ. Мөнгөний нийлүүлэлт гэхэд жилдээ 60 гаруй хувийн өсөлттэй. Нөөц мөнгө ч ялгаагүй жилийн 60, 70 хувийн өсөлттэй байна. Тиймээс хатуу бодлого гэж үзэж болохгүй. Жилийн мөнгөний нийлүүлэлтийн 60, 70 хувийн өсөлт эцсийн дүндээ инфляцад нөлөөлнө. Одоо инфляц долоо байгаа хэдий ч оны эцэст 10 хувь болохыг үгүйсгэх аргагүй. Олон улсын санхүүгийн байгууллагын хүлээлт бол 15 орчим хувьтай байгаа. Мөнгөний нийлүүлэлтийн энэ огцом өсөлтийг багасгахгүй бол эцсийн дүндээ үнийн өсөлт бий болгох нь тодорхой.

-Зээлийн хүү одоогийнхоос доош буух боломж байна уу. Арилжааны банкууд хадгаламжийн хүү өндөр учраас зээлийн хүү өндөр тогтдог хэмээн тайлбарладаг?

-Эргээд л бид судалгаатай ярих ёстой. Зээлийн хүүг хар зургаар аваад үзвэл хадгаламжийн хүү, нэмэх нь банкуудын хийж буй ашиг байдаг. Банкны ашиг өндөр байгаа нь Монголд банкны сектор эрсдэлтэй, зах зээл нь том биш, зээлийн түүх ч сайн үүсээгүйтэй холбоотой. Харин хадгаламжийн хүү өндөр байгаа нь өнөө л инфляцтай холбоотой. Тиймээс зээлийн хүүг бууруулахад хадгаламжийн хүүг бууруулах ёстой. Хадгаламжийн хүү буурахад инфляц нам төвшинд байх хэрэгтэй. Мөн банкны салбар дахь өрсөлдөөний сайжруулах шаардлагатай. Суурийг нь өргөсгөх. Эдийн засаг нь өсөөд ирэхээр зээлийн эрсдэл буурна. Энэ үед банкууд зээлээ бага хүүтэй олгож эхэлнэ.

-Төсвийн бодлого, мөнгөний бодлого хоорондоо зөрчилдөөд байна л даа?

-Мөнгөний бодлогыг хэрэгжүүлж байгаа газар нь Засгийн газраас хараат бус Монголбанк, Сангийн бодлогыг явуулж байгаа нь Засгийн газар, Сангийн яам. Монголбанкны гол зорилго бол инфляц, Сангийн бодлого бол эдийн засгийн өсөлтийг дэмжих, бүтцийн өөрчлөлтийг сайжруулах. Нийгмийн халамжийг түгээх. Энэ хоёр байгууллага бол тэс өөр. Өөр зорилготой. Мөнгө тараах бодлого буюу Сангийн бодлого. Мөнгөний бодлого сангийн бодлоготойгоо уялдах ёстой гэж яриад л байдаг. Хоорондоо уялдаад Сангийн хүчтэй тэлэх бодлого явуулснаар эдийн засгийн нийт эрэлтийг өсгөөд барааны үнийг өсгөх эрсдэлтэй. Барааны үнэ өсөхөөр Монголбанкны зорилгод харшилна. Тиймээс Монголбанк инфляцыг нам түвшинд барихын тулд мөнгөний бодлогоо хатууруулах шаардлагатай болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, нэг талдаа Сангийн хүчтэй тэлэх бодлого явж байдаг. Нөгөө талд нь мөнгөний хумих бодлого явуулж байна. Сонгууль дөхөөд ирэхээр хоёр бодлогын зааг ялгаа улам тодрох бололтой.

-Төр хоёр банкттай болчихлоо. Нэг нь Хөгжлийн банк. Нөгөө нь Төрийн Банк. Хөгжлийн банк зорилгоо умарталгүй ажиллавал амжилт олох биз?

-Төрийн банкиг хувьчлах нь тодорхой. Угаасаа төрд байсан банкуудыг хувьчилж байсан. Хөгжлийн банкны тухайд манай арилжааны банкууд шаардлагатай урт хугацаатай томоохон зээлийг өгөх боломжгүй учраас энэ гажгийг арилгахаар Засгийн газар Хөгжлийн банкиг байгуулахаар болсон. Зээлийн хугацаа урт, хэмжээ ч том байхаар асуудлыг давхар шийдэж байгаа. Үүгээрээ Хөгжлийн банк нэг талаараа давуу боловч томоохон төслөө дагаад эрсдэл нь өндөр. Зээлийн эргэн төлөлт ямар байх юм, хяналтын системийг зөв тавихгүй бол дахиад л Засгийн газрын зарлага шиг болж мэдэх юм. Хөгжлийн банкны өмнөөс Засгийн газар бонд гаргачихсан байгаа. Баталгаа, бонд гаргасан хэдий ч үүнийг Монгол Улсын гадаад өр гэж тооцох хэрэгтэй. Хөгжлийн банк гэдэг эцсийн дүндээ бол Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг. Цэвэр банк биш.

Эдийн засаг маань эргээд л халалтынхаа үе рүү явж байна

-Дэлхийн санхүүгийн хямралаас манай улсын эдийн засаг бүрэн ангиржиж чадсан уу?

-Хямралын нөлөөг жижигхэн үзүүлэлт болох банкуудын чанаргүй зээлийн хэмжээнээс харж болно. Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ сүүлийн үед огцом буурч, долоо орчим хувьтай явна. Хямралын нөлөө алга болсон гэж ойлгож болно. Харин нэг анхаарах зүйл нь хямралаасаа сургамж авч чадсан уу. Үгүй юу. Хямралаас сургамж аваад ямар нэгэн дорвитой бодлогын өөрчлөлт хийгдсэн үү гээд аваад үзэхээр энэ гээд хэлчих зүйл алга. Хямралын өмнө байсан бодлогууд тэр чигтээ одоо үргэлжилж байна. 2008, 2009 оны хямрал яг өнөөдөр давтагдаа гэхэд Монгол Улс эргээд хямралд автах нь гэсэн дүр зураг харагдаж байна. Өөрөөр хэлбэл, бодлогын хувьд томоохон өөрчлөлт гараагүй. Нэг ахицтай зүйл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. Энэ хууль харамсалтай нь 2013 оноос хойш хэрэгжинэ. Эдийн засаг маань эргээд халалтынхаа үе рүү явж байна.

-Голланд өвчний шинж тэмдэг манай эдийн засагт ажиглагдаж байна уу?

-Томоохон уул уурхайн төслүүд Монгол Улсад хэрэгжих гэж байна. Оюу толгой, Таван толгой гээд. Энэ хоёр эдийн засгийн төслийг өнөөгийн эдийн засагтай харьцуулбал асар том. Эдгээр төслүүд эдийн засагт ороод ирэхээр ялангуяа уул уурхайн төсөл учраас Монгол Улсад Голланд өвчний шинж тэмдэг илэрнэ. Эдийн засагт Голланд өвчин ямар сувгаар дамжиж нөлөөлдөг болохыг манайхан тэр бүр ярихгүй байна л даа. Голланд өвчний ойлголт дутуу байна. Өвчний гол шинж тэмдэг гэвэл эдийн засаг нь дотогшоогоо чиглэсэн. Өөрөөр хэлбэл, үйлдвэр, үйлчилгээ нь дотоод зах зээл рүүгээ хандсан. Экспорт луугаа бага чиглэсэн байдаг. Дотоод зах зээл дээрх бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ бусад орны зах зээлийн үнээс харьцангуй өндөр. Эдийн засгийн бүтэц ч гэсэн томоохон өөрчлөлтөд ордог. Гадаадад экспортлохгүй

барааны нийт хувийн жин дотоодын зах зээл дээр нэлээд өндөр болж ирдэг. Үүнийг Голланд өвчин гэж нэрлээд байгаа юм. Түүнээс эдийн засгийн уналт бол биш. Голланд өвчинд нэрвэгдсэн орон эдийн засгийн өсөлттэй ч байдаг. Тиймээс Голланд өвчин эдийн засгийн уналтыг авчирна гэж хэлж болохгүй. Голланд өвчинд нэрвэгдсэн орон гадаад зах зээл дээр өрсөлдөх чадваргүй болдог юм.

-Уул уурхайн томоохон төслүүд өсөлт, их мөнгөний сургийг дуулгах болсон. Цаашид манай эдийн засгийн өсөлт хурдаа улам авах уу?

-Уул уурхайн томоохон төслүүд хэрэгжээд эхлэхээр үйлдвэр үйлчилгээ нэмэгдээд эдийн засаг одоогийнхоосоо илүү өснө. Валютын сангийн тооцолсноор манай улсын эдийн засгийн жилийн өсөлт ирэх гурван жилийн дотор 30 хүртэлх хувьд хүрнэ гэж тооцоолсон байна билээ. Манай улсад хэрэгжих төслүүд өөрөө том зах зээлтэй учраас эдийн засгийн өсөлтийг гарцаагүй авчирна. Бид сохроор юунд найдаж байгаа вэ гэхээр эдийн засгийн том өсөлт гарна. Хүмүүс ажилтай болно. Иргэд ажилтай болж байгаа учраас цалинтай болно. Цалинтай учраас ядуурал буурна гэж найдаж байна. Түүнээс эдийн засгийн өсөлт тэд болоход ядуурал тэдэн хувиар буурна гэсэн тооцоолол хийхэд хэцүү. Уг нь ийм тооцоог хийх шаардлагатай.

Б. БАЯРТОГТОХ